



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12-сарын 21 өдөр

Дугаар 693

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит
үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг
шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Замын-Үүд, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудыг үйл ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлэн ажиллах болсонтой холбогдуулан “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 845 (найман зуун дөчин тав) байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 510 дугаар тогтоолын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

